



## The Social Representation of Mongolian Manhood and the Armed Forces

Terbish Bilguun

Second lieutenant, Master, Researcher, Policy analysis centre, Defense Research Institute of Mongolia  
E-mail address: [bilguun@mids.gov.mn](mailto:bilguun@mids.gov.mn), ORCID: 0009-0003-0660-5684

Received: 03 February 2026  
Accepted: 25 March 2026

Revised: 15 March 2026  
Published online: 30 March 2026



### ABSTRACT

This article explores how shifting social expectations toward men in contemporary Mongolia are connected to changes in the authority, legitimacy and social position of the Armed Forces. It argues that transformations in public perceptions of masculinity, media representation, and institutional power relations may be reshaping how military service is understood within society. The study suggests that the Armed Forces are increasingly influenced by broader social change rather than operating as an isolated institution. Instead of providing definitive conclusions, the article offers an exploratory framework for understanding the intersection of masculinity, power, and military institutions, and proposes directions for future research on civil-military relations and institutional transformation in Mongolia.

**Keywords:** masculinity, armed forces; civil-military relations; military sociology, social change.

## Монгол эр хүний нийгмийн дүр төрх ба Зэвсэгт хүчин

Тэрбиш Билгүүн

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Бодлогын дун шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэслэгч, [Bilguun@mids.gov.mn](mailto:Bilguun@mids.gov.mn), ORCID: 0009-0003-0660-5684

### ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд Монгол эрэгтэйчүүдэд хандсан нийгмийн хүлээлт, түүний өөрчлөлт нь Зэвсэгт хүчний эрх мэдэл, легитим байдал болон нийгмийн байр суурийн хоёрын холбоог авч үзлээ. Эр хүний дүр төрхийн өөрчлөлт, хэвлэл мэдээллийн орчин дахь дүрслэл болон төрийн цэргийн байгууллагуудын эрх мэдлийн харилцаа нь цэргийн албаны тухай нийгмийн ойлголтыг өөрчилж байж болзошгүй юм. Тус өгүүллийн хүрээнд Зэвсэгт хүчнийг бие даасан институт гэхээс илүү нийгмийн өргөн хүрээний өөрчлөлт, олон нийтийн хандлага, үнэт зүйлсийн өөрчлөлтийн дунд буй социал институтын хувьд авч үзсэн болно. Энэхүү өгүүлэл нь эршүүд чанар, эрх мэдэл, цэргийн институтын холбоог тайлбарлах шинжилгээний хүрээг санал болгож, Монгол дахь иргэн-цэргийн харилцаа болон цэргийн институтын өөрчлөлтийг цаашид судлах боломжит чиглэлүүдийг санал болгож байна.

**Түлхүүр үгс:** эршүүд чанар; зэвсэгт хүчин; иргэн-цэргийн харилцаа; цэргийн социологи; нийгмийн өөрчлөлт.

## Удиртгал

Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа баталж, нийгэм, улс төрийн тогтолцоогоо өөрчилснөөс хойш Монголчуудын нийгмийн амьдралын олон хүрээнд гүнзгий өөрчлөлт, хувьсал гарсан билээ. Энэхүү нийгмийн өөрчлөлт, шилжилтийн салшгүй нэг хэсэг нь яах аргагүй цэргийн институтэд гарсан хувьсал юм.

1990-ээд оноос өмнөх социалист нийгмийн үед цэргийн институтийн тогтолцоо, номлол нь тухайн үеийн геополитикийн орчин, нийгмийн шинж чанартай уялдан илүү өргөн хүрээтэй, улс төр, нийгмийн амьдралд нөлөөлөх чадвартай, нийгмийн байр суурь, эрх мэдлийн хувьд харьцангуй хүчтэй байв.

Харин ардчиллын дараагаар батлан хамгаалах салбарын бүтэц, зохион байгуулалтад томоохон өөрчлөлт орж, тухайн үеийн армийн бүрэлдэхүүнийг цомхотгосон байдаг. Тэрхүү үед болж байсан нийгмийн эрс өөрчлөлт нь тухайн үеийн цэргийн салбарт төдийгүй нийгмийн өргөн хүрээнд тогтворгүй, хурцадмал нөхцөл байдлыг үүсгэж байжээ.

Хэрэв тийм бол өнөөгийн Монголын нийгэмд “цэрэг байх,” “эр хүн байх” эсвэл “эршүүд байх” гэдэг ойлголтууд нь ямар утга агуулгатайгаар төлөвшиж, нийгмийн оюун санаанд хэрхэн дүрслэгдэж байна вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Түүхэн уламжлалын үүднээс авч үзвэл эрэгтэй хүн гэр бүл, овог аймаг, улс үндэстнийхээ аюулгүй байдлыг хамгаалах үүрэгтэй нийгмийн субъект байсаар ирсэн бөгөөд нийгмийн оюун санаанд эр хүнийг дайчин, хамгаалагчийн дүрээр төлөөлүүлж ойлгож ирсэн. Тиймээс ч Зэвсэгт хүчин нь уламжлалт утгаараа эрчүүд давамгайлсан салбар юм. Зэвсэгт хүчин нь аливаа улс, үндэстний бат бэх байдал, тусгаар тогтнолын илэрхийлэл, төрийн сүр хүчний бэлгэдэл, аюулгүй байдлын баталгаа мөн. Гэвч нийгэм дэх эр хүний уламжлалт дүр төрх, эршүүд чанарын талаарх ойлголт өөрчлөгдөх нь Зэвсэгт хүчний нийгмийн байр суурь, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд хүртэл нөлөөлөх хүчин зүйлс болж болзошгүй юм.

Энэхүү өгүүллийн хүрээнд Монголын нийгмийн өөрчлөлтийн нөлөөгөөр эр хүний нийгмийн дүр төрх хувьсаж буйг, энэ нь нийгмийн зохион байгуулалт болон Зэвсэгт хүчний легитим чанарт хэрхэн нөлөөлж байгааг авч үзнэ. Дэлгэрүүлбэл, уламжлалт “эр цэрэг,” “эршүүд чанар”-ын өөрчлөлтийг Монголын нийгмийн нөхцөлд тайлбарлах, энэ нь Зэвсэгт хүчний нэр хүнд, нийгмийн оюун санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох, улмаар Монгол Улсын Батлан Хамгаалах үйл ажиллагаа, нийгмийн тогтвортой байдалд үзүүлж болох үр дагаврыг онолын хүрээнд тайлбарлахад оршино.

## Онолын хүрээ

Монголын нийгэм дэх эр хүний дүр төрхийн тухай, түүний өөрчлөлтийн талаар авч үзэхийн тулд нийгмийн олон хүчин зүйлийн талаар, тухайлбал: соёлын өөрчлөлт, хууль эрх зүйн шинэчлэл, технологийн хөгжил зэрэг зүйлсийг өргөн хүрээнд нь авч үзэх шаардлага гарна. Энд нийгмийн өөрчлөлтийн тухай дурдаж байгаа нь ихэвчлэн даяаршлын нөлөөлөл болон барууны нийгмийн хөгжлийн загварыг шүүлтүүргүй хуулбарлаж ирсэн хандлага түүний Монголын нийгэмд буцаахад бэрх, гүнзгий нөлөөлөл хийсэн үр дагаврын тухай агуулж байна гэж товчхондоо ойлгож болно (*Bilguun 2025, 66, 73*). Одоо өгүүллийн гол сэдэвтэй

холбоотой зарим голлох онол, судалгааг дурдъя.

Монголын нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн сэтгэлийг эмзэглүүлсэн элдэв гэмт хэрэг ихэд гарах болсон. Үүний ихэнх холбогдогч нар нь хөвгүүд, эрэгтэйчүүд байх хандлага ажиглагдаж байна. Ялангуяа гэр бүлийн хүрээнд, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг олон давтамжтай ажиглагдана.

Тийм бол эршүүд байдал буюу “masculinity” гэж юу вэ, энэ тухай шинжлэх ухааны түлхүүр судалгааны ажил, онолын гол төлөөлөгчдөөс дурдвал Австралийн социологич Р.В Коннел юм. Түүний эршүүд байдлыг судалсан онолын гол ойлголт бол “hegemonic masculinity” буюу тухайн нийгэмд байх ноёрхогч эр хүний дүр бөгөөд түүний үзсэнээр эршүүд байдал гэдэг нь нийгэм-түүхийн нөхцөлдүүлгээр бий болсон нийгмийн конструкц ба эршүүд байдлыг хувь хүний сэтгэл зүйн болон биологийн өгөгдөлтэй холбож ойлгох нь өрөөсгөл гэжээ (*Connell 2005*).

Коннел эр хүний дүр төрхийг тайлбарлахдаа нийгмийн харилцаагаар дамжин хэвшиж, төр, цэрэг, хөдөлмөрийн зах зээл, соёлын хүрээнд хадгалагддаг хэмээжээ. Тиймээс нийгэмд байх эр хүний дүр төрх нь хувь хүний түвшинд хамаарах асуудал биш ба эрх мэдлийн харилцаа, эдийн засгийн бүтэц, оюун санааны тогтцоор зохион байгуулагдсан тогтолцоо байдлаар илэрхийлэгддэг байна (*Connell 2005, 45*). Энэ өнцгөөс харвал эр хүний дүр төрх, түүний өөрчлөлт нь ганцхан эрэгтэйчүүдэд л хамаатай асуудал биш бөгөөд социал утгатай, нийгмийн гүн гүнзгий асуудал болж байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор Америкийн клиник сэтгэл зүйч Николас Грот, түүний хамтран судлаач Жан Бирнбаум нарын судалгааны бүтээл “*Men Who Rape: The Psychology of the Offender (1979)*” буюу шууд орчуулбал “Бэлгийн хүчирхийлэл үйлддэг эрчүүд” гэсэн номыг дурдах хэрэгтэй (*Groth 1979, 2*).

Тэдний судалгаанд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн эрэгтэйчүүдийн гэмт хэргийн сэдэл, сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг системтэйгээр судалж, шинжилсэн байдаг. Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн дур ханамж авах гэхээс илүү эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн асуудал, нийгмийн байр суурь, эрх мэдэлтэй холбоотой дутуугийн мэдрэмжтэй холбож дүгнэсэн байдаг. Зарим судалгаанд эрэгтэй хүн үл хүндлэгдэх, гадуурхагдах, сэтгэл зүйн хувьд сул дорой байдалд орох нь түрэмгийлэл болон бэлгийн хүчирхийлэл үйлдэх нэгэн нөхцөл болж болохыг тэмдэглэсэн байдаг (*Groth 1979, 88*).

Энэхүү зүй тогтлоор харвал нийгэмд байх давамгайл эр хүний дүр төрх тодорхой бус болох, нийгмийн өөрчлөлтийн хүрээнд эрэгтэйчүүдийн эрх мэдэл, нэр төр, нийгмийн үүргийг чиглүүлж байсан уламжлалт үнэт зүйлс өөрчлөгдөх нь олон сөрөг нөлөөг үзүүлж байна. Үр дагаварт нь эрэгтэйчүүд нийгмийн харилцаанд өөрийгөө батлах боломжгүй болж, түүнийгээ түрэмгийлэл, хүчирхийлэл зэрэг буруу арга замаар нөхөх хандлагатай байдаг.

Хэрэв эр хүний дүр төрх, эршүүд байдал нь институтийн хүрээнд бодитоор хэвшиж, нийгмийн утга агуулгатай болдог гэж үзвэл түүнийг тогтвортой, ёс суртахууны үүрэг хэлбэрээр зохион байгуулж ирсэн нийгмийн институт бол цэргийн институт мөн. Тиймээс эр хүний дүр төрхийн өөрчлөлтийг ойлгохын тулд цэргийн институттэй хэрхэн зөрчилдөж, эсвэл таарч, тохирч байна вэ гэдэг

асуултыг цэргийн социологийн хүрээнд тавих нь зайлшгүй юм.

Түүнчлэн энд дурдах нэг чухал судалгааны эх сурвалж бол Эрика Л.Фрейзерийн “*Military Masculinity and Postwar Recovery in the Soviet Union*” гэх бүтээл юм. Монгол Улсын орчин үеийн цэргийн уламжлал нь Зөвлөлтийн цэргийн институтийн туршлага, загвартай холбоотой, олон талаар төстэй шинжтэй байдаг. Фрейзерийн судалгаанд Дэлхийн хоёрдугаар дайны дараах ЗХУ-ын төр, засаг эр хүний нийгмийн дүр төрхийг цэргийн институтийн хүрээнд дахин төвлөрүүлэн зохион байгуулах зорилготой соёлын бодлого, цогц үйл ажиллагаа хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.

Дайны жилүүдэд хүн амын хохирол асар их гарч, эмэгтэйчүүд фронтод өргөнөөр оролцсон нь эр хүний нийгмийн дүр, цэргийн албатай холбогдох уламжлалт ойлголтыг тодорхой бус болгосон нөхцөл үүсжээ. Энэ нөхцөлийг ЗХУ-ын төр нийгмийн тогтвортой байдал, үндэсний ижилсэлд эрсдэл дагуулж болзошгүй хэмээн үзэн эмэгтэйчүүдийн цэргийн алба дахь оролцоог хязгаарлах, харин цэргийн алба, бэлтгэл сургуулилыг эр хүний ёс суртахуун, хүмүүжил, иргэний үүргийн үндсэн шалгуур болгон дахин бэхжүүлэх бодлого баримталсан байна (*Fraser 2019*).

Фрейзер эршүүд чанарыг байгалиас заяасан чанар гэж үзээгүй бөгөөд төрийн бодлого, институтийн зохион байгуулалт, нийгмийн өдөр тутмыг практикаар тасралтгүй бүтээгдэж, хэлбэрждэг нийгмийн үзэгдэл хэмээн тайлбарладаг. Тэрээр ЗХУ-ын дайны дараах сэргэлтийн жилүүдийг эдийн засаг, улс төрийн хүрээнээс гадна эр хүн байх нийгмийн утга, ёс суртахууны хэм хэмжээ, эрх мэдэл, дэг журмыг дахин зохион байгуулах өргөн хүрээний төсөл байсан гэж үзсэн.

Үүнтэй холбогдуулан өнөөгийн Монголын нийгмийн дүр төрхийн түгээмэл хэлбэр нь ЗХУ-ын идеал эр хүний дүр төрхтэй ойролцоо, магадгүй адилхан байх магадлалтай юм. Монголд эршүүд чанар, эр хүний нийгмийн дүр төрхийн тухай өөрсдийн соёлын болон нийгмийн нөхцөл байдлын үүднээс судалсан судалгаа ховорд тооцогдох бөгөөд ихэвчлэн ноёрхогч мэдлэгийн тогтолцоо болох жендер, болон феминист байр сууринаас судалсан судалгаа харин элбэг байна.

Цэргийн социологийн сонгодог хоёр онолуудыг энэ хүрээнд авч үзвэл Самуэл П. Хантингтон болон Чарлз С. Москос зэрэг сэтгэгч нарын бүтээлүүд онцгой байр суурь эзэлнэ. Зэвсэгт хүчин нь энгийн нэг хөдөлмөрийн байгууллага биш бөгөөд харин нийгмийн онцгой үүрэг, хариуцлага хүлээсэн мэргэжлийн институт юм. Хантингтоны онолоор цэргийн институтийн үндэс нь цэргийн тусгай мэргэшил, сахилга бат, дэг журам, цэргийн ёс зүй юм. Түүний судалгааны үндсэн асуулт бол “Орчин үеийн ардчилсан засаглалтай улс хэрхэн иргэний эрх мэдлийг сулруулахгүйгээр хүчирхэг армитай байх вэ?” гэдэгт хариулт өгөх байв. Энэ өвөрмөц байдал нь төрийн өмнө хүлээсэн онцгой үүрэг, улс төрөөс харьцангуй ангид байх зарчим болон иргэний хяналтын тогтолцоогоор тайлбарлагддаг (*Huntington 1957*).

Харин Москос цэргийн байгууллагын өөрчлөлтийг институтийн болон хөдөлмөрийн зах зээлийн зарчимд суурилсан буюу “occupation” гэсэн хоёр зохион байгуулалтын хүрээнд тайлбарладаг. Институтийн загварын үед зэвсэгт хүчин нь нийгэмд нэр хүнд өндөртэй, нийгмийн ёс суртахууны бэлгэдэл, хамтын үнэт

зүйлсэд суурилсан байгууллага байж, алба хаагчид тусгай үүрэгтэй, нийгмийн өмнө хариуцлага хүлээсэн субъект гэдгээ ухамсарладаг.

*Occupation* загварт гэрээт харилцаа, ажиллах нөхцөл, цалин хөлс, карьерын боломж, хувь хүний ашиг хонжоо зэрэг хүчин зүйлс илүү чухал болдог ба зэвсэгт хүчнийг хөдөлмөрийн зах зээлийн зарчимд суурилсан нийгмийн бусад ажил мэргэжилтэй төстэй болгодог. Москосын тайлбарласнаар энэхүү өөрчлөлт нь институтийн “онцгой” шинжийг сулруулж, нийгмийн бусад энгийн байгууллагатай адилхан зарчмаар ажилладаг бүтэцтэй төстэй болгодог (*Moskos 1977*).

Хантингтон зэвсэгт хүчнийг төрийн өмнө тусгай үүрэг хүлээсэн, мэргэшлийн мэдлэг, сахилга бат, ёс зүйд суурилсан мэргэжлийн институт гэж тодорхойлж, түүний легитим чанар буюу хүлээн зөвшөөрөгдөх байдал нь улс төрөөс ангид байх, иргэн-цэргийн харилцааны тэнцвэрээр хадгалагдана гэж үздэг. Харин Москос зэвсэгт хүчний зохион байгуулалтын загварыг нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөгөөр тайлбарладаг. Тэр нь институтийн үнэт зүйл давамгайлсан хэлбэрээс хөдөлмөрийн зах зээлийн зарчимтай төстэй “occupation” загвар руу шилжиж буй хувьсал ажээ.

Эдгээр онолуудын хүрээнд товч дүгнэвэл цэргийн институтийн өөрчлөлтийг нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн хүрээнд мөн тайлбарлах боломжтой байна. Монгол Улсын хувьд цэргийн институтийн бие даасан шинж, эрх мэдэл, нийгэм дэх нэр хүндэд нөлөөлөх хүчин зүйлсийг дан гадаад хүчин зүйлс болох эдийн засаг, газар зүйн байрлал, эсвэл дэлхийн улс төрийн нөхцөл байдалтай холбож үзэх нь учир дутагдалтай. Харин социал нөлөөллүүдийг авч цааш дэлгэрүүлэн нарийвчлах шаардлага байна. Тэдгээрийн нэг нь эршүүд чанар, Монгол эр хүний дүр төрхийн тухай асуудал юм. Тиймээс энэхүү өгүүллийн дараагийн хэсэгт Монголын нийгэмд Монгол эрэгтэйчүүдийн тухай зарим тоо баримтуудыг авч үзэн нийгэм дэх эр хүний дүр төрхийн өөрчлөлтийг хэлэлцэнэ.

### **Хэлэлцүүлэг**

Энэхүү хэсэгт дээрх онолын хүрээнд дэвшүүлсэн эр хүний дүр төрхийн өөрчлөлтийг Монголын нийгмийн бодит нөхцөлд задлан шинжлэхийг зорьж байна. Өмнөх хэсэгт үзсэнчлэн эршүүд байдал, эр хүний дүр төрх нь дан ганц хувь хүний зан төлөв, сэтгэл зүйн хүрээний асуудал биш бөгөөд институтийн байгуулалт, эрх мэдлийн бүтэц, нийгмийн оюун санаанд тогтсон үнэт зүйлсийн хүрээнд хэвшдэг нийгмийн үзэгдэл юм. Тиймээс Монголын нийгэмд эрэгтэйчүүдтэй холбоотой зарим үзүүлэлтүүдийг дурдах нь эр хүний нийгмийн дүр төрх, төсөөлөл яагаад тогтворгүй, тодорхой бус болж эхэлснийг өргөн зургаар нь ойлгоход нэмэртэй гэж үзэж байна. Гэвч дараах тоо баримтууд нь эр хүний дүр төрхийг шууд утгаараа илэрхийлж буй үзүүлэлт биш гэдгийг энэ дашрамд дурдъя.

### **Эрэгтэйчүүдтэй холбоотой зарим тоо баримтууд**

Дээр онолын хэсэгт үзсэнчлэн нийгмийн нийтлэг, тогтсон эр хүний дүр төрх бүдгэрэх, ойлгомжгүй болох нь эрчүүдийн уламжлалт байр суурийг ганхуулж, зарим нөхцөлд түрэмгийлэл, хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Хэрэв ийм өнцгөөс харвал нийгэмд гарч буй гэмт хэрэг, хүчирхийллүүдийн тодорхой хэлбэрүүд нь зөвхөн хувь хүний нөхцөлөөс үл шалтгаалсан нийгмийн нөхцөлдүүлэг, социал үндэс шалтгаантай.

Монгол Улсад гарсан зарим гэмт хэргийн тоо баримтыг дурдвал 2010-2019 оны хооронд жилд дунджаар 16,900 хүн нас барсан тоо баримт бүртгэгдсэн бөгөөд үүний 2,8% нь амиа хорлолтоос үүдэлтэй байна. Эдгээрийн 85% нь эрэгтэйчүүд байв (*Эрүүл мэндийн Яам ба СЭМҮТ 2024, 8*). Мөн 2022 оны гэмт хэргийн статистик ч үүнийг батлах бөгөөд 18-24 насны 5,439 эрэгтэй, 25-29 насны 3,492 эрэгтэй гэмт хэрэгт холбогдсон нь тухайн насны гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 90%-ийг эзэлж байна. Тэдгээр гэмт хэрэгт холбогдогчдын 57.3% нь ажилгүй, 16,6% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байв (*2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, 2023*). Энэ нь амьжиргаа болон эдийн засгийн баталгаагүй байдал, нийгмийн гадуурхал, нийгмийн нэгдмэл үнэт зүйлгүй болох зэрэг манай нийгмийн суурь асуудлуудын үр дүнд эрэгтэйчүүд хариуцлагагүй, зорилгогүй хэв маяг руу түлхэгдэж буйг илтгэнэ.

Боловсролын хувьд мөн л эрэгтэйчүүд хоцрогдох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, хөвгүүдийн сурлагын үзүүлэлт охидтой харьцуулахад харьцангуй доогуур байгаа бөгөөд сургуулиас завсардах, их дээд сургуульд элсэж, дээд боловсрол эзэмших хувь бага байна. Дэлхийн банкны Mongolia Gender Assessment тайланд дурдсанаар хөвгүүд сургууль завсардах магадлал 33%-аар их байна гэжээ (*World Bank 2024, 41*). Мөн эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ч бас давхар бодолцох хэрэгтэй юм. Зарим эрэгтэйчүүдийн ажилгүй, зорилгогүй амьдралын хэв маягт шилжсэн байдлыг буруутгахаас илүүтэй энэ нөхцөл байдлыг бий болгож буй нийгмийн асуудал, тогтолцооны талаас нь авч үзэх хэрэгтэй.

Түүнчлэн хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр эр хүнийг сөрөг дүрээр харуулах нь давамгайлж, уламжлалт эр хүний төсөөлөл алга болох хандлагатай байна. Телевиз, сошиал медиад архидсан, хүчирхийлэл үйлддэг, хариуцлагагүй эр хүний тухай үе үе хөндөгдөж байгаа нь нийгмийн бодит байдлын илэрхийлэл, тусгал болж, Монгол эрэгтэйчүүд нийгэмд “сул дорой, хүчирхийлэгч” гэсэн нийгмийн ухамсарт сөрөг хэвшмэл ойлголтууд тогтох хандлагатай байна. Энэ нь залуу хөвгүүд, эрэгтэйчүүд тэдний хүмүүжил, төлөвшилд буруу үлгэр дуурайлал, сөрөг нөлөөтэй бөгөөд нийгэмдээ асар их хор уршигтай юм. Энэ талаар цаашид системтэй судлах шаардлагатай.

### **Эр хүний дүр төрх Зэвсэгт хүчинд**

Өнөөгийн Монголын нийгэмд эршүүд чанарын ойлголт, эр хүний дүр төрх өөрчлөгдөж, тэднээс хүлээх нийгмийн хүлээлт, үүрэг тодорхойгүй болох үйл явц Зэвсэгт хүчнээс ангид байх боломжгүй. Учир нь Зэвсэгт хүчин нь түүхэн талаасаа эрэгтэйчүүд давамгайлсан салбар мөн ба эх орон, нэр төр, тэсвэр хатуужил, үнэнч байдал зэрэг амьд үлдэх түүхэн туршлагын үүднээс бүрэлдэн тогтсон үнэт зүйлсийг тээдэг, эр хүнийг хүмүүжүүлдэг институт юм. Дан ганц аюулгүй байдлын үүргийг хангахаас гадна нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх эршүүд чанарын босгыг тодорхойлдог нийгмийн чухал үүрэгтэй. Энэ талаасаа цэргийн институт нь нийгэм дэх эр хүний дүр төрхийн өөрчлөлтийг судалж болох судалгааны талбар юм. Иргэн-цэргийн харилцаа, цэргийн эрх мэдэл, тусгаар байдал, нийгмээс ирж буй олон талын эерэг болон сөрөг хандлагууд зэрэг олон асуудал үүнд багтана.

Олон нийтийн түгээмэл хандлагаар төрийн бүтэц, зохион байгуулалтын загвараас үл шалтгаалан цэргийн дүрэмт хувцастай алба хаагч бүрийг Батлан

хамгаалах Яам, Зэвсэгт хүчинтэй холбож ойлгох хандлага түгээмэл байдаг. Энэ утгаараа хэдий өөр яамны харьяа бүтцэд хамааралтай, жишээлбэл: Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Дотоодын цэрэг зэрэг байгууллагуудыг бүгдийг нь “цэргийн алба” хэмээн нийтлэг байдлаар нь ойлгогдог. Улмаар төрийн цэргийн байгууллагад холбогдох аливаа сөрөг үйл явдал нь тухайн байгууллагын хүрээнээс давж, Зэвсэгт хүчний талаарх нийгмийн төсөөлөл, итгэл үнэмшилд дам байдлаар нөлөөлөх хандлагатай байдаг.

Монголын нийгэмд хамгийн сүүлд гарсан, олон нийтийн хүрээнд өргөн хэлэлцүүлэгдсэн үйл явдал бол Дотоодын цэргийн ангид гарсан хугацаат цэргийн албан хаагч хоорондын дүрмийн бус харилцаа, түүнээс үүдсэн олон нийтийн хүчтэй хариу үйлдэл юм (Тамир 2025). Энэ үйл явдлаас олон зүйлийг ажиглаж болох бөгөөд ерөнхийдөө цэргийн дотоод соёл, эрх мэдэл, байр суурийн талаар нийгмийн хандлагыг үзүүлж байна. Олон нийтээс ирэх сөрөг хариу үйлдлүүд нь ганцхан байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа асуудал хэмээн өнгөц дүгнэж болохгүй. Харин өнөөгийн нийгэмд цэргийн институтийн үүрэг, байр суурь, ёс зүй ямар байх ёстой вэ гэсэн илүү гүнзгий асуудлыг эрэлхийлж байна.

Цэргийн албаны талаарх нийгмийн оюун санаанд байгаа төсөөлөл, хандлага нь аюулгүй байдлын болон нийгмийн дотоод зохион байгуулалт, дэг журамд хүртэл нөлөөтэй, олон талын ач холбогдолтой. Тэдгээрийн нэг нь энэхүү “эршүүд байдал”, эр хүний дүр төрх юм.

Нийгэм дэх эр хүний дүр төрхийн өөрчлөлт нь гэмт хэргийн гаралтаас гадна эр хүний идеал дүр төрх, эх оронч үзэл, сахилга бат зэрэг үнэт зүйлсийг бэлгэдлээрээ хадгалдаг Зэвсэгт хүчин, түүний нийгэм дэх нэр хүнд, легитим байдалд нөлөөлөх хандлагатай гэж үзэх үндэстэй. Цэргийн байнгын алба хаагчдын ёс зүй, албандаа итгэх итгэл, албан хаагч хоорондын харилцаа зэрэг зарим асуудлууд нь аливаа байгууллагын дотоод асуудал гэхээс илүү нийгэмд эр хүний тухай ойлголт, үнэлэмж өөрчлөгдөж буй өргөн хүрээний үйл явцтай холбоотой байж болох юм.

Энгийнээр тайлбарлавал Монголын нийгэм эр хүнийг харах, тэднээс хүлээх хүлээлт өөрчлөгдөхийн хэрээр цэргийн байгууллагын “эр хүнийг” төлөвшүүлэх уламжлалт тогтолцоо нийгмийн шинэ хэм хэмжээтэй зөрчилдөх шинж илэрч байна. Өмнө нь чухалд тооцогддог байсан “эр хүн” болох шалгуурууд нь өнөөгийн Монголын нийгэмд ач холбогдолгүй мэт ойлгогдохын зэрэгцээ залуу хөвгүүд, эрчүүд иргэний үүргээ биелүүлэх хүсэл зоригт сөргөөр нөлөөлж байх боломжтой юм. Үүний улмаас залуу үе, гэр бүлүүдийн хувьд цэргийн алба нь ач холбогдолгүй, эсвэл зарим талаар эрсдэлтэй сонголт мэтээр ойлгогдох хандлага дэлгэрч байна. Энэхүү үзэгдлүүд нь Монгол хүний эх орондоо үйлчлэх, төрөө дээдлэх уламжлалт ухамсар, иргэний үүргийг сулруулах, мөн аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа, Зэвсэгт хүчний хүний нөөцийн нөхөн хангалтад урт хугацаандаа сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.

### **Зэвсэгт хүчний нийгэм дэх байр суурь**

Монгол Улсын аюулгүй байдлын өнөөгийн бүтцийг авч үзвэл хүч хэрэглэх хууль ёсны эрх мэдэл нь бодитоор Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудад төвлөрсөн хэв шинжтэй байна. Цагдаа, Дотоодын цэрэг зэрэг

байгууллагуудад өдөр тутмын дотоод аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахиулах, хууль ёсны дагуу хүчирхийлэл хэрэглэх эрх мэдэл хадгалагддаг бөгөөд төсөв, санхүүжилтийн хувьд ч Зэвсэгт хүчнээс харьцангуй давуу нөхцөлтэй болгосон байдаг. Нэг хэсэг үе “Монгол Улсад цэрэг, арми хэрэггүй” гэх дискурсууд эрчимжиж, мөн адил үзэл санаатай хүмүүс эрх баригчдын дунд байсан нь нууц биш билээ. Өнөөгийн энэ бүтэц нь санаатай болон санамсаргүй байдлаар Монголын Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, эрх мэдлийг хязгаарлагдмал болгож, олон мянган алба хаагчдын амьдралын баталгаа, тэдний нийгмээс үзүүлэх хүндлэл, нэр хүнд зэрэг олон зүйлд шууд болон шууд бус байдлаар нөлөөлсөн.

Ерөнхийдөө асуудлын гол мөн чанар нь төрийн цэргийн байгууллагуудын нийгмийн нэр хүндийн тухай биш бөгөөд харин төрийн хууль ёсны дагуу хүч ашиглах эрх мэдэл хаана төвлөрч байгаа эсэхээс өнөөгийн Монголын нийгэм дэх эрх мэдлийн тогтолцооны зарим далд үйлчлэлийг мэдэж болно.

Цэргийн институтийг дан ганц дайн байлдааны үүргээр л ойлгох нь учир дутагдалтай ба Монгол эр хүнийг нийгэмд оролцох, бие даасан ухамсартай иргэн бэлтгэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх зэрэг олон чухал ач холбогдолтой. Тийм учраас цэргийн, Москосын нэр томъёогоор бол “институтийн” шинжийг орхиж болохгүй.

Зэвсэгт хүчний өнөөгийн байр суурийг системтэйгээр судлах, цаашид үндэсний эрх ашгийг хангасан өөр алтернатив бүтцийн хувилбаруудыг олох, энэ асуудалтай холбоотой социал нөлөөллийг судлах шаардлага байсаар байна.

### Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд өнөөгийн Монголын нийгэмд эршүүд чанарын утга, ойлголт өөрчлөгдөж буй үйл явцыг Зэвсэгт хүчний нийгэм дэх байр суурийн өөрчлөлттэй холбон авч үзлээ. Эрэгтэйчүүдэд уламжлалт байдлаар оноож ирсэн хамгаалагч, эх оронч үүрэг зэрэг үнэт зүйлс бүдгэрэхийн хэрээр тэдгээрийг хадгалж, түгээж ирсэн нийгмийн институтэд ч мөн давхар нөлөөлж байна. Зэвсэгт хүчин улс орны аюулгүй байдлын үүргийг хэрэгжүүлэхийн сацуу нийгмийн ёс суртахуун, дэг журам, хамтын үнэт зүйлсийг төлөвшүүлэх орон зай байсаар ирсэн. Тиймээс нийгэмд эршүүд чанар, эр хүний нийгмийн дүр төрх өөрчлөгдөх нь цэргийн институтийн үйл ажиллагаа, легитим байдалд илрэхийн хажуугаар нийгмийн оюун санааны түвшинд хүртэл нөлөөлж байх боломжтой.

Хэлэлцүүлэг хэсэгт дурдсан эрэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэмт хэрэг, амиа хорлолтын тоо баримтууд нь нийгэм дэх эр хүний дүр төрхийг шууд утгаараа илэрхийлэхгүй боловч эрэгтэйчүүдтэй холбоотой гол асуудлууд, тэдний нөхцөл байдлыг харуулж байна. Түүнчлэн нийгэмд дүрэмт хувцастай алба хаагч болгоныг олон нийт “цэрэг” гэсэн дүрээр хүлээн авах хандлага байдаг тул төрийн цэргийн байгууллагуудыг нэгэн цул байдлаар нь хамруулан ойлгох нь түгээмэл бий. Үүнээс шалтгаалан аль нэг төрийн цэргийн байгууллагуудтай холбоотой асуудал бүрийг Зэвсэгт хүчинтэй хамаатуулах нь Зэвсэгт хүчний талаарх олон нийтийн хандлага, итгэлд сөргөөр нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл нийгмийн оюун санаа, ухамсарт цэргийн алба гэдэг бол иргэний үүрэг, “төлөвшсөн эр хүн” гэдгээ нийгэмдээ нотолж буй нотолгоо байх байтал сөрөг хандлагыг л үлдээж байна.

Нөгөө талаас аюулгүй байдлын тогтолцоонд төрийн эрх мэдлийн өдөр тутмын

илрэл нь хууль сахиулах байгууллагуудад төвлөрөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь нарийн төвөгтэй асуудал боловч Зэвсэгт хүчний тухай нийгмийн төсөөлөл сөрөг болох эсвэл аажимдаа сулрах нь алсдаа Монгол Улсын эрх ашигт харшилна. Энэ нь зөвхөн байгууллагын нэр хүндийн тухай асуудал огт биш бөгөөд төрийн эрх мэдлийн бүтэц, иргэн-цэргийн харилцааны тэнцвэр, ардчилсан тогтолцоо зэрэгтэй хамаарах өргөн хүрээний асуудал юм. Тиймээс цэргийн институтэд хамаарах асуудлыг зөвхөн тухайн салбарын асуудал гэж үзэхгүйгээр нийгмийн үнэт зүйлс, эр хүний дүр төрхийн өөрчлөлт, төрийн эрх мэдлийн бүтэцтэй уялдуулан хамтатган ойлгох нь чухал.

### Цаашдын судалгааны чиглэл

Эл өгүүлэлд хөндсөн асуудлуудад шийдэл өгөхөөс илүү эршүүд чанар, эрх мэдэл, Зэвсэгт хүчний байр суурь гурвын холбоо өнөөдөр хэрхэн өөрчлөгдөж болохыг нээж харах эхний оролдлого юм. Тиймээс цаашдын судалгаа нь (1) Монголын нийгэмд “эршүүд чанар”, “цэрэг байх” гэсэн ойлголтууд ямар хэм хэмжээ, шалгуураар хэвшиж байгаа вэ гэдгийг тогтоох; (2) төрийн хүч, эрх мэдэл ямар байгууллагуудаар дамжин илүү хэрэгжиж байна вэ, (3) тухайн нөхцөлд Зэвсэгт хүчин нь эр хүнийг нийгэмшүүлэх нийгмийн ач холбогдол нь оршиж байна уу, эсвэл алба хаах нь зах зээлийн шинж рүү хэлбийж байна уу гэдгийг шалгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл цаадын судалгаа нь эршүүд чанарын тухай нийтлэг ойлголт хэрхэн өөрчлөгдөж байна, төрийн эрх мэдэл бодит амьдрал дээр хаана төвлөрч байна, энэ хоёрын огтлолцолд Зэвсэгт хүчний социал утга, байр суурь хэрхэн дахин тодорхойлогдож байна гэдэг гол асуудал дээр төвлөрч судлагдана.

### Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. 2023. “2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал.” Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Цагдаагийн ерөнхий газар, Улаанбаатар, 10.
2. Bank, World. 2024. *Mongolia Gender Assessment*. Washington, DC: World Bank. doi:10.1596/42182.
3. Bilguun, Terbish. 2025. “Social Dimensions of Defense Policy: Tensions between National Consciousness and Liberal Democratic Values.” *Mongolian Journal of Strategic Studies* 35 (97): 64-74. <https://doi.org/10.65315/mjss.v35i97.4486>.
4. Connell, R W. 2005. *Masculinities*, 2nd ed. Cambridge: Polity.
5. Fraser, Erica L. 2019. *Military Masculinity and Postwar Recovery in the Soviet Union*. Toronto: University of Toronto Press.
6. Groth, A. Nicolas. 1979. *Men Who Rape: Psychology of the Offender*. New York: Plenum Press.
7. Huntington, Samuel P. 1957. *State and the Soldier: The Theory and Politics of Civil-Military Relation*. Cambridge: Harvard University Press.
8. Moskos, Charles C. 1977. “From Institution to Occupation: Trends in Military Organization.” *Armed Forces & Society* 4: 41-50. <https://doi.org/10.1177/0095327X7700400103>.
9. Тамир, А., 2025. Зодуулсан цэргийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагагүй. 12 24. Нэвтэрсэн 2026 оны 02 10. <https://news.mn/r/2840849/>.
10. Эрүүл мэндийн Яам, ба СЭМҮТ. 2024. ““Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх” судалгааны төслийн тайлан.” Resarch Report, Улаанбаатар. <https://sudalгаа.gov.mn/X9ELxS>.